

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... дугаар
сарын-ний өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 1/232 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ /О.Төмөрхуяг/-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Тариф батлах тухай” 219 дүгээр тогтоол, 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Тариф батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ

ЗОХИЦУУЛАГЧ

Л.ДАШМЯГМАРЖАВ

ЗОХИЦУУЛАГЧ

Ц.НОРОВЖАМЦ

ЗОХИЦУУЛАГЧ

Д.ЦОГОО

*Эрчим хүчний зохицуулах хорооны
... оны ... дугаар сарын ...-ний өдрийн
... дүгээр тогтоолын хавсралт*

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчдийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт халаалт байгууллагын	Эзлэхүүнээр	төг/м ³	3,210.00	
		Хэмжүүрээр	хувьсах	төг/ГЖ	27,641.50
			тогтмол	төг/м ³	1,063.30
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын халаалт	Эзлэхүүнээр	төг/м ³	2,000.00	
		Хэмжүүрээр	хувьсах	төг/ГЖ	24,570.20
			тогтмол	төг/м ³	945.20
3	Албан байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан		төг/ м ³	4,000.00	
			төг/хүн	5,000.00	
4	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна)		төг/м ²	1,400.00	
5	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан		төг/м ³	4,000.00	
6	Дулааны эрчим хүчний үйлчилгээний тариф		40 м ² хүртэл талбайтай	төг/сар	3,000.00
			41-80 м ² талбайтай	төг/сар	5,000.00
			81 м ² -с дээш талбайтай	төг/сар	10,000.00